

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГУУДЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Аудитын код: САГ-2017/26/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор Ж.Болормаа

Утас: 261628 Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	7
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	8
2.7	Шилэн дансны мэдээлэл	10
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	11
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	11
2.9.1	Санхүүгийн тайлангийн нэгтгэлийн талаар	11
2.9.2	Түүвэрт хамрагдсан төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн талаар	11
2.9.3	Барилга, хот байгуулалтын яамны хөрөнгө оруулалтын талаар	12
2.9.4	Чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн талаар	12
2.9.5	Барилга, хот байгуулалтын яамны талаар	12
2.9.6	“Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын талаар	13
2.9.7	БХБЯ-ны харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн талаар	14
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	14
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	15
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	15
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	16
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	16
3	Менежментийн захидал	17
3.1	Түүвэрт хамрагдсан төслүүдийн тайлангийн талаар	18
3.2	Чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн талаар	19
3.3	Дотоод аудитын ажлын талаар	20
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	21
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	21
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	22
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	23
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	24
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	25

1 Аудитын гэрчилгээ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Г.МӨНХБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Барилга, хот байгуулалтын сайд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

- Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн 47.0 хувийг эзэлж буй “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар 30,919.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь тухайн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид бус гэж дүгнэсэн,
- УБ хотын VII, XIV, МҮОНРТ хорооллын орон сууц, дэд бүтцийн төслийн ажилтнуудын цалингийн төсөв 153.7 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан алдаа, зөрчлийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр таньд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Барилга, хот байгуулалтын сайд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 03/973 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна. Мөн аудитын түүвэрт хамрагдсан Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл G0204-MON, Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл, УБ хотын VII, XIV, МҮОНРТ хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх нэгжүүд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа ҮАГ-т ирүүлсэн байна.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 35 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс төсвийн шууд захирагч 25, төсвийн төвлөрүүлэн захирагч 1, төсөл хөтөлбөр 5, ТӨҮГ 2, яамны хөрөнгө оруулалтын болон норм, нормативын сангийн 2 данс хамрагдсан байна.

Үүнээс 30 санхүүгийн тайланд аудит хийгдэж, 4 тайлан түүвэрт хамрагдаж 1 тайлан аудит хийгдээгүй нэгтгэгдсэн нь Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг АХБ-ны тайлан авах хугацаанд хийхээр төлөвлөсөнтэй холбоотой байна.

Аудит хийгдээгүй нэгтгэгдсэн төслийн төсөв Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нэгтгэсэн төсвийн 2 хувийг эзэлж байна.

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Дархан хотын бохир усны менежментийн MON3244/MON3245 төсөл”-ийн санхүүжилтийн төсөв Дархан-Уул аймгийн Засаг даргын төсвийн багцад батлагдсантай холбоотой Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нэгтгэсэн тайланд нэгтгэгдээгүй байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Барилга, хот байгуулалтын яамны эрхэм зорилго нь барилга, хот байгуулалт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын ая тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллаж байна. Үүнд,

- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

- Орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх;
- Салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Төрийн захиргаа, хүний нөөц, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тогтолцоог хэрэгжүүлэх, удирдлагаар хангах.

Дээрх зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д “Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байна” гэж заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайд нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тус яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Барилга, хот байгуулалтын яам нь дараах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Үүнд,

- Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль
- Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Барилгын тухай хууль
- Геодези зураг зүйн тухай хууль
- Газрын тухай хууль
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Авилгатай тэмцэх тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд

нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмууд байна.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй гол хуулиуд болох Барилгын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд шинэчлэгдэж 2016 оноос мөрдөж эхэлсэн байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Барилга, хот байгуулалтын яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 15 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2015 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн, дараах нэмэлт өөрчлөлтийг тусгах нь зүйтэй байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг хэлнэ” гэж заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны тайлан, тус газрын даргын үр дүнгийн гэрээний биелэлттэй танилцлаа.

Тус газар нь 2016 онд 3 чиглэлээр нийт 34 ажил хийхээр төлөвлөснөөс 92.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Тайлант хугацаанд 9 чиглэлээр дотоод аудит хийж нийт 45 зөвлөмж өгч ажилласан байна. Гэвч тус газрын даргын үр дүнгийн гэрээгээр 23 нэр төрлийн ажил дүгнэгдсэн бөгөөд бүгд 100 хувийн биелэлттэй гэж тайлагнасан нь учир дутагдалтай байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны тайланг уншиж танилцахад цаашдаа анхаарах дараах асуудал байна. Үүнд,

- Алдаа, зөрчил арилгах, ажил сайжруулах зөвлөмжийг биелүүлэх хугацаа заагаагүй
- Зөвлөмжийг шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд хаяглаагүй
- Тодорхой хугацаанд биелэгдэх боломжгүй зөвлөмж өгсөн
- Зөвлөмжийн биелэлтийг хянаж үзээгүй
- Тайлан товч бөгөөд тодорхой бичигдээгүй
- Санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй зэрэг асуудал байна.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналтын эрсдэл “дунд” байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйл ангиар хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар Барилга, хот байгуулалтын сайдын харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг 4,606.2 сая төгрөг, төсөв зарцуулах эрхийг 65,894.1 сая төгрөгөөр баталснаар өмнөх оноос орлого 5,213.7 сая төгрөг буурч, зарлага 8,052.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт төвлөрүүлэх орлогын дүнгээс 1,751.2 сая төгрөгийг гадаад зээл тусламжийн орлогоос санхүүжүүлэхээр баталсан бол БХБЯ болон ГЗБГЗЗГ-ын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 2,200.0 сая төгрөгөөр баталснаас 2,338.9 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Барилга, хот байгуулалтын яамны харьяа байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү
0	Барилга, хот байгуулалтын сайдын төсөв	65,894.1	61,111.3	(4,782.8)
1	БХБЯ-ны хөрөнгө оруулалт	50,961.4	48,531.9	(2,429.5)
2	БХБЯ-ны аппарат	1,808.3	1,795.4	(12.9)
3	Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл G0204-MON	1,751.2	1,230.6	(520.6)
4	Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл	1,106.2	106.0	(1,000.2)
5	УБ хотын VII, XIV, МҮОНРТ хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл	1,000.0	487.8	(512.2)
6	Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл хэрэгжүүлэх нэгж	246.3	227.7	(18.5)
7	Зүүн өмнөд говийн хот, хил орчмын хотын хөгжил төсөл- нэмэлт санхүүжилт-АХБ	100.0	-	(100.0)
8	ГЗБГЗЗГ-Тусгай зориулалтын шилжүүлэг	6,686.1	6,589.9	(96.2)
9	ГЗБГЗЗГ-Агентлаг	2,234.7	2,142.1	(92.6)

Хүснэгтээс харахад нийт төсвийн гүйцэтгэл 61,111.3 сая төгрөгөөр тайлагнагдаж батлагдсан төсвөөс 4,782.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Нийт төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар өмнөх он болон батлагдсан төсөвтэй харьцуулан харуулбал дараах байдалтай байна.

/сая төгрөг/

д/д	Зардлын эдийн засгийн ангилал		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны		Зөрүү /+илүү,-дутуу/	
				Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Өмнөх оны гүйцэтгэлээс	Төлөвлөгөө нөөс
	21	Урсгал зардал	13,070.7	12,836.8	11,770.5	(1,300.2)	(1,066.4)
	210	Бараа, ажил үйлчилгээний зардал	12,740.2	5,941.5	4,974.5	(7,765.7)	(967.0)
1	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,273.2	1,927.2	1,921.5	(4,351.7)	(5.7)
2	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	684.5	212.2	211.3	(473.2)	(0.8)
3	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	547.4	48.0	48.5	(498.9)	0.5
4	2104	Хангамж, бараа материалын зардал	372.7	119.7	118.7	(254.0)	(1.0)
5	2105	Нормативт зардал	3.6	0.6	0.6	(3.0)	-
6	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44.0	29.5	27.3	(16.7)	(2.2)
7	2107	Томилолт, зочны зардал	132.4	21.8	19.4	(113.0)	(2.5)
8	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,540.6	3,230.8	2,379.5	(1,161.1)	(851.3)
9	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,141.7	351.7	247.6	(894.1)	(104.0)
10	213	Урсгал шилжүүлэг	330.4	6,895.3	6,795.9	6,465.5	(99.4)

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

11	22	Хөрөнгийн зардал	22,972.5	52,420.7	49,340.9	26,368.4	(3,079.9)
12	23	Эргэж төлөгдөх зээлийг хассан цэвэр зээл	27,472.7	636.5	-	(27,472.7)	(636.5)
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН			63,515.8	65,894.1	61,111.3	(2,404.4)	(4,782.8)

Дээрх хүснэгтээс харахад тайлант оны бараа, ажил үйлчилгээний зардал өмнөх оны гүйцэтгэлээс 7,765.7 сая төгрөгөөр, батлагдсан төсвөөс 967.0 сая төгрөгөөр багассан байна. Тайлант онд Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын тусгай зориулалтын шилжүүлгийн 6,795.9 сая төгрөгийг урсгал шилжүүлэгт бүтэн дүнгээр тайлагнасантай холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшил өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 4,351.7 сая төгрөгийн зөрүү гарсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсөвтэй зардлын зүйл ангиар харьцуулбал төсөвлөснөөс хэтэрсэн зардал байхгүй байна.

Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, зориулалтаар авч үзэхэд үндсэн үйл ажиллагааны зардал 2,270.0 сая төгрөг байгаа нь нийт төсвийн 3.7 хувийг эзэлж байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn веб сайтад Барилга, хот байгуулалтын яамны харьяа байгууллагууд Шилэн данс цэсийг байршуулж 3 төрлийн мэдээллийг оруулсан байна. Тухайлбал,

- ГЗБГЗЗГ төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 49 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 27 мэдээлэл, бусад 61 нийт 137 мэдээлэл, ТОСК ТӨҮГ нь 2016 онд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 17,698.5 сая төгрөгийн 951 гүйлгээ, зарлагын 14,620.8 сая төгрөгийн 389 гүйлгээг холбогдох баримтын хамт, “Дэд бүтэц” төсөл хөрөнгөжүүлэх нэгж төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг 12 удаа, үйл ажиллагааны санхүүжилтийн орлогын 96.6 сая төгрөгийг, “Ирээдүй” цогцолбор хороолол, “Буянт-Ухаа” орон сууцны хорооллын бохир ус цэвэрлэх байгууламжийн цахилгаан, дулаан хангамжийн ажлын төлөвлөгөө, Транс импекс интернэшнл ХХК-тай байгуулсан конторын түрээсийн 2.3 сая төгрөгийн гэрээ зэргийг тус тус мэдээлсэн байна.

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ, “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл” төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн тайланд аудит хийсэн Хараат бус аудитын компани болон Орхон аймгийн аудитын газар тухайн байгууллагын шилэн дансны талаар аудитын тайланд тодорхой мэдээлэл бичээгүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын тайлангаар Барилга, хот байгуулалтын яамны харьяа байгууллагууд дараах мэдээллийг шилэн дансанд байршуулсан байна. Үүнд,

Мэдээллийн төрөл	Мэдээллийн мөнгөн дүн /сая төгрөг/	Мэдээллийн хэрэгсэл	
		Цахимаар	Мэдээллийн самбараар
Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой	94,265.1	82	21
Бусад	76,738.8	162	87
НИЙТ ДҮН	171,003.9	244	108

Төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 4 төрлийн мэдээллийг улирал бүр шилэн дансны мэдээллийн веб сайтад мэдээлсэн байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 23 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Санхүүгийн тайлангийн нэгтгэлийн талаар

Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн эхний үлдэгдэл ТОСК ТӨҮГ-ын өмнөх оны тайлангийн дүнгээр буюу 2,617.8 сая төгрөгөөр зөрүүтэй бөгөөд тайлан нэгтгэх явцад нийт 1,294.6 сая төгрөгийн алдаа гарсан байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлээр танилцуулж аудитын явцад залруулга хийлгэсэн болно.

2.9.2 Түүвэрт хамрагдсан төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн талаар

УБ хотын VII, XIV, МҮОНРТ хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төслийн ажилтнуудын цалин 216.1 сая төгрөгөөр батлагдсан боловч гүйцэтгэлээр 369.9 сая төгрөг буюу 153.7 сая төгрөгөөр, нийт урсгал зардал батлагдсан төсвөөс 124.3 сая төгрөгөөр хэтэрсэн байна.байна.

Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл

Төслийн үйл ажиллагаа дуусаж байгаатай холбогдуулан ажилтануудын цалингийн зардлын төсөв 60.3 сая төгрөгөөр батлагдаж 59.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан боловч сүүлийн хагас жилийн цалин 78.4 сая төгрөгийг он гараад нөхөж авсныг санхүүгийн байдлын тайланд авлагаар тусгаагүй байна.

Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл G0204-MON

Төслийн нэгж нь МУЗГ-аас үзүүлж буй Гааль болон НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдийн засгийн ангиллаар бүртгээгүй, барилга, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгийн зардлыг бараа үйлчилгээний урсгал зардалд тайлагнасан байна.

АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй тус төслийн санхүүгийн тайлан өмнөх онд болон тайлант онд аудит хийгдээгүй ТЭЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байна.

Төслийн барилга, байгууламжийн зардалд батлагдсан төсвийн үлдэгдлээс зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулах хүсэлтийн дагуу тоног төхөөрөмж авахад 249.8 сая төгрөгийг зарцуулсан боловч төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд батлагдсан ангиллын дагуу барилга, байгууламжийн зардалд бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 17 дугаар зүйлийн 17.1-д “Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна” гэж заасны дагуу 8.9.1 дэх заалт болон Иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус биелүүлж ажиллах,

2.9.3 Барилга, хот байгуулалтын яамны хөрөнгө оруулалтын талаар

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 48,531.8 сая төгрөг, Хөгжлийн банкны санхүүжилтээр 44,829.1 сая төгрөг нийт 93,360.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн боловч Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 6.1-д “... барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана” гэж заасны дагуу бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлээр танилцуулж аудитын явцад 124,342.5 сая төгрөгийн дуусаагүй хөрөнгө оруулалтыг залруулж бүртгэлд тусгуулав.

2.9.4 Чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн талаар

Төрийн сангийн 900029401 тоот дансны барьцааны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нийт 9,247.2 сая төгрөгийн 4,068.8 сая төгрөг нь 2011-2013 онд үүссэн, 5,178.4 сая төгрөг нь 2014-2016 онд үүссэн барьцааны мөнгөн хөрөнгө байгаа нь Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14 дүгээр зүйлийн 14.3-д “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14 дүгээр зүйлийн 14.3-д заасныг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

2.9.5 Барилга, хот байгуулалтын яамны талаар

БХБЯ-ны ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Болортуяа нь 2016 оны 5 сарын 31-ний өдөр “Зууны гүүр” ХХК-тай “Эрсдэлтэй ажлын байрны судалгаа

хийх” 39 дугаартай гэрээг байгуулж гэрээний үнийн дүн 9.9 сая төгрөгөөс урьдчилгаа 6.5 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээг дүгнээгүй, гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй байна.

Мөн 2016 оны 3 сарын 10-ны өдөр хуульч Т.Цэен-Ойдовтой Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай 25 дугаартай гэрээ хийж 9.8 сая төгрөгийг шилжүүлсний дараа 15-ны өдөр 26 дугаартай нэг ижил ажлын даалгавартай 9.5 сая төгрөгийн гэрээг дахин байгуулсан байна. Гэрээний нийт үнийн дүн 19.3 сая төгрөгийг бүрэн төлсөн боловч гэрээний 3.6-д заасны дагуу хуульч үүргээ биелүүлээгүй байна.

2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт болон зөрчил арилгах албан шаардлага авсан Санхүү, эдийн засгийн хэлтсийн ажилтнуудад цаг хугацаанд нь тайлангаа гаргасан гэсэн үндэслэлээр цалингийн урамшуулалд 4.2 сая төгрөг олгосон нь Сангийн сайдын 2006 оны 292 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам”-ын заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 30.1 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах акт тогтоосон.

Барилга, хот байгуулалтын сайд асан З.Баянсэлэнгийн эд хөрөнгийн ашиглалтын картанд бүртгэлтэй 2015 онд худалдан авсан 3.4 сая төгрөгийн үнэтэй зөөврийн компьютер /Dell/ нь байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй байгаа боловч бодитоор оршин байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг бодитой хийх, дутсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх зөвлөмж өгсөн.

2.9.6 “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын талаар

Засгийн газрын 2016 оны 60 дугаар тогтоолоор Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолборын санхүүжилт болох 14,241.2 сая төгрөгийг АНУ-ын Экспорт Импортын банкнаас зээл авах хүртэлх хугацаанд Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг зөвшөөрсний дагуу ТОСК ТӨҮГ-ын дансаар дамжуулан санхүүжилт хийсэн нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй ажил гүйлгээ бөгөөд дээрх тогтоолын дагуу нийт 18,080.2 сая төгрөгийг /урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн байсныг залруулсан/ авлагаар бүртгэсэн,

Тайлант жилийн санхүүгийн тайлангаар НӨАТ-ын буцаан авалт 11,101.6 сая төгрөгөөр тайлагнасан боловч харьяалагдах татварын хэлтэстэй тооцоо нийлж акт үйлдээгүй, татварын авлагын дүнг баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

ТОСК ТӨҮГ-ын ерөнхий захирлын 2016 оны А/49, А/70 дугаартай тушаалын дагуу 32 айлын 1,480.3 м² талбайтай 1,950.4 сая төгрөгийн үнэ бүхий орон сууцыг Нийслэлийн орон сууцны фондод үнэ төлбөргүй шилжүүлж үйл

ажиллагааны зардлаар бүртгэсэн,

2015 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаар 3,204.4 сая төгрөгийн алдагдал тайлагнасан боловч ТОСК ТӨҮГ-ын захирлын 2016 оны А/17 дугаар тушаалаар 2014 оны санхүүгийн тайлангийн татварын дараах цэвэр ашгаас 5 хувиар тооцон 341.3 сая төгрөгийг Нийгмийн хөгжлийн санд хуваарилж 242.0 сая төгрөгийн байрны дэмжлэгийг албан хаагчдад олгосон,

ТӨХ-ны 2015 оны 778 дугаар тогтоолоор баталсан 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн бусад зардлыг 25.0 сая төгрөгөөр баталсан боловч дэд захирал Д.Оюунжаргалд хүүхдийн сургалтын төлбөр 65.0 сая төгрөгийг олгож үйл ажиллагааны бусад зардлаар бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад төлбөрийг барагдуулах акт тогтоосон.

2.9.7 БХБЯ-ны харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн нийт 30 байгууллагын санхүүгийн тайлан аудитад хамрагдсанаас 27 байгууллагын санхүүгийн тайлан “Зөрчилгүй”, ТОСК ТӨҮГ, Говь-Алтай аймгийн ГХБХБГ-ын санхүүгийн тайлан “Хязгаарлалттай”, Говьсүмбэр аймгийн ГХБХБГ-ын санхүүгийн тайлан “Сөрөг” дүгнэлт авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэсэн зарчмыг баримталж ажиллах зөвлөмж өгсөн.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

ТОСК ТӨҮГ-ын авлага, өр төлбөрийн дүнг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, борлуулсан бүтээгдэхүүний өртгийн тооцоолол алдаатай, хөрөнгө оруулалт хамтын ажиллагааны гэрээгээр 13 аж ахуйн нэгжид 21,819.6 сая төгрөгийн санхүүжилт олгож 2,053.7 сая төгрөгийн зээлийн хүүгийн төлбөр бодогдсоноос 2,643.6 сая төгрөгийн үндсэн зээл, 790.4 сая төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдсөн нь үндсэн зээлийн 12 хувь, хуримтлагдсан хүүгийн төлбөрийн 38 хувь байна. Энэ нь Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр хийсэн санхүүжилтийн эргэн төлөлт хангалтгүй байгааг харуулж байна.

Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 48 дугаар тогтоолоор Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор (UBM)-ыг худалдан авахад зориулж Хөгжлийн банкнаас авсан зээл, зээлийн хүүгийн төлбөр болох нийт 10.4 сая ам.доллар, 153.1 сая төгрөгийг хянаж нягталсны үндсэн дээр улсын төсөвт тусгахыг Сангийн сайдад, Батлан хамгаалах яамны балансад тусгах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад даалгасан байна.

Төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэж гараагүй, нэгтгэлийн Э-тайлангаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайлан алдаатай байгаа зэрэг нь ЗГСНТ-д нэгтгүүлэхэд зөрүү гарах эрсдэлтэй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын дээр дурдсан асуудал болон Засгийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолын биелэлтийг нарийвчлан шалгах шаардлагатай байна

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 125,782.2 сая төгрөгийн 19 залруулга, 1,321.1 сая төгрөгийн 43 зөвлөмж, 2,289.7 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 28,647.2 сая төгрөгийн 10 албан шаардлага өгөгдсөн байна.

Барилга, хот байгуулалтын сайдын нэгтгэсэн тайлангийн алдаа, зөрчлийн нийт дүн 158,040.2 сая төгрөг бөгөөд үүнээс залруулагдсан алдааг хасвал 32,257.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

БХБЯ-ны аппаратын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд 30.1 сая төгрөгийн, ТОСК ТӨҮГ Засгийн газрын 2013 оны 263 дугаар тогтоолыг зөрчсөн, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зөрчсөн зөрчлүүдэд нийт 2,257.4 сая төгрөгийн, аймгуудын ГХБХБ-ын газруудад тогтоосон 2.2 сая төгрөгийн нийт 2,289.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд 107.4 сая төгрөгийн, ТОСК ТӨҮГ-т 28,325.4 сая төгрөгийн, Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл хэрэгжүүлэх нэгжид 0.4 сая төгрөгийн, аймгуудын ГХБХБ-ын газруудад 60.3 сая төгрөгийн нийт 28,493.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн байна.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Барилга, хот байгуулалтын яамны албан тушаалтнуудын томилолт болон бусад зардлын 138.2 сая төгрөгийг харьяа байгууллагуудаар санхүүжүүлсэн зөрчилд 1 албан шаардлага, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийгдээгүй тайлан нэгтгэсэн талаар, норм, нормчлолын сангийн зардлын талаар, улсын төсвийн орлого төвлөрүүлэлтийн талаар 3 зөвлөмж өгөгдсөн байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 1 сарын 20-ны өдрийн 03/230 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн өмнөх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэсэн боловч Барилга, хот байгуулалтын яамны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн техник хяналтын зардлын 27.0 сая төгрөгийг зохих анхан шатны баримтын бүрдэлгүй “Барилгын хөгжлийн төв” УТҮГ-т шилжүүлж зардлаар бүртгэсэн зөрчлийг арилгаж, анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлж тооцоо хийх албан шаардлагыг биелүүлээгүй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлын түвшинг гүйцэтгэлийн үе шатанд үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2% буюу 2,708.0 сая төгрөгөөр тогтоов. Энэ нь төлөвлөлтийн үед тооцсоноос 7.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үр дүнгийн нэгтгэсэн тайланд 351.0 сая төгрөгийн залруулга хийгдсэнтэй холбоотой байна.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

- Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн 47.0 хувийг эзэлж буй “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ын аудит хийсэн санхүүгийн тайланд 30,919.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь тухайн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид бус гэж дүгнэсэн,
- УБ хотын VII, XIV, МҮОНРТ хорооллын орон сууц, дэд бүтцийн төслийн ажилтнуудын цалингийн төсөв 153.7 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан алдаа, зөрчлийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим чиглэгдсэн.

Энэ нь Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

**3.1 ТҮҮВЭРТ ХАМРАГДСАН ТӨСЛҮҮДИЙН
ТАЙЛАНГИЙН ТАЛААР**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

УБ хотын VII, XIV, МҮОНРТ хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл, Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл, Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн санхүүгийн тайланд түүврээр аудит хийхэд батлагдсан цалингийн төсвийг 153.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн, 78.4 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, МУЗГ-аас үзүүлж буй гааль болон НӨАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдийн засгийн ангиллаар бүртгээгүй, барилга, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгийн зардлыг бараа үйлчилгээний урсгал зардалд тайлагнасан алдаа, зөрчил нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлагдсан журмын заалттыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага-ыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ, Сангийн сайдын 2015 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 7 дугаар тушаалын заалт,

Байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй Иж бүрэн байх батламж мэдэгдэл зэргийг хангаж ажиллах

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, төслийн хэрэгжилтэд тавих хяналт сулрах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 ЧАНАРЫН БАТАЛГААТ ХУГАЦААНЫ БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
--	---

ҮАГ-ын ажиглалт

Төрийн сангийн 900029401 тоот дансны барьцааны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нийт 9,247.2 сая төгрөгийн 4,068.8 сая төгрөг нь 2011-2013 онд үүссэн, 5,178.4 сая төгрөг нь 2014-2016 онд үүссэн барьцааны мөнгөн хөрөнгө байгаа нь Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14 дүгээр зүйлийн 14.3-д заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14 дүгээр зүйлийн 14.3-д “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна” гэж заасныг үндэслэн барьцааны хөрөнгийг суллах арга хэмжээ авах

Эрсдэлүүд

Хуулийн заалт хэрэгжихгүй байх, эзэн холбогдогч тодорхойгүй барьцааны мөнгөн хөрөнгө нэмэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 Дотоод аудитын ажлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 чиглэлээр 34 ажил төлөвлөснөөс гүйцэтгэлээр 92.7 хувийн биелэлттэй гэж тайлагнасан боловч тус газрын даргын үр дүнгийн гэрээний биелэлтийг тулган шалгахад 23 ажлын гүйцэтгэл дүгнэгдсэн байна.

Тайлант хугацаанд 9 чиглэлээр дотоод аудит хийж нийт 45 зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийн биелэлтийг тооцож тайлагнаагүй байгаа нь “Яамны дотоод аудитын хорооны ажиллах журам”-ын 6.4-д “Дотоод аудитын зөвлөмжийг албан ёсоор хүргүүлснээс хойш тогтоосон хугацаанд шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний талаар дотоод аудитад хамрагдсан байгууллага, нэгжээс ТЕЗ-д мэдээлэл ирүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д “дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг хэлнэ” гэж заасны дагуу үйл ажиллагаагаа төлөвлөж, биелэлтийг хянаж ажиллах

Эрсдэлүүд

Дотоод хяналт сулрах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Балансын үзүүлэлт	/мянган төгрөг/	
	2015 оны 12 дугаар сарын 31	2016 оны 12 дугаар сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	377,424,139.5	519,549,378.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,520,575.3	15,969,201.1
АВЛАГА	134,497,282.3	149,792,456.4
УРЬДЧИЛГАА	44,980,089.7	34,112,342.4
БАРАА МАТЕРИАЛ	172,410,954.4	59,602,458.3
НӨӨЦИЙН БАРАА	25.7	25.7
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	11,015,212.1	260,072,895.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	289,981,849.2	341,449,689.5
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,000.0	1,000.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	289,980,849.2	341,448,689.5
Биет хөрөнгө	289,903,194.7	332,134,016.6
Биет бус хөрөнгө	77,654.5	8,640,864.4
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	673.81
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	667,405,988.7	860,999,068.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР	340,126,587.4	384,829,089.7
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43,941,569.1	70,893,013.2
Богино хугацаат зээлийн өглөг	5,528,390.5	-
Өглөг	26,536,872.7	41,299,441.6
Урьдчилж орсон орлого	11,876,305.9	29,593,571.6
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	296,185,018.2	313,936,076.5
Урт хугацаат зээл	296,185,018.2	313,936,076.5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	327,279,401.3	476,169,978.7
Засгийн газрын хувь оролцоо	327,279,401.3	476,169,978.7
Хуримтлагдсан үр дүн	311,852,810.2	462,016,077.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	278,933.2	265,794.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	667,405,988.7	860,999,068.4

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөг/	
	2015 оны 12 дугаар сарын 31	2016 оны 12 дугаар сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	138,650,203.8	193,512,799.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,767,607.3	63,057,079.2
Нийтлэг татварын бус орлого	38,918,939.2	62,669,893.2
Тусламжийн орлого	6,848,668.0	387,186.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	92,882,596.5	130,455,720.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	105,242,349.5	138,485,571.1
УРСГАЛ ЗАРДАЛ	32,594,489.7	138,485,571.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,716,154.5	82,583,676.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,491,511.1	7,013,681.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	791,426.7	786,462.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	663,659.0	630,751.9
Хангамж, бараа материалын зардал	1,075,281.8	51,233,674.4
Нормативт зардал	5,994.0	3,337.1
Эд хогшил, урсгал засварын зардал	94,545.1	90,439.9
Томилолт, зочны зардал	208,539.9	110,820.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,326,335.6	18,703,869.2
Бараа үйлчилгээний бусад зардал	3,058,861.2	4,010,639.8
ХҮҮ	34,740.9	5,121.3
ТАТААС	3,895.0	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,839,699.4	55,896,773.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	72,647,859.8	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	33,407,854.3	55,027,228.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	22,361,062.9	23,110,570.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,411,882.2	18,975,521.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	48,357,035.0	59,162,277.4

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Цөөнхийн оролцоо	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	285,955,181.1	0.00	285,955,181.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(6,072,360.7)	0.00	(6,072,360.7)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,882,820.5	0.00	279,882,820.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(18,235.5)	0.00	(18,235.5)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	(942,218.6)	0.00	(942,218.6)
Тайлант үеийн үр дүн	48,357,034.9	0.00	48,357,034.9
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,279,401.3	0.00	327,279,401.3
2016 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	327,279,401.3	0.00	327,279,401.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	90,519,667.2	0.00	90,519,667.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	417,799,068.5	0.00	417,799,068.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	(13,139.0)	0.00	(13,139.0)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	(342,095.5)	0.00	(342,095.5)
Орлогын тайланд хүлээн завшаараагүй олз, гарз	(436,132.6)	0.00	(436,132.6)
Тайлант үеийн үр дүн	59,162,277.4	0.00	59,162,277.4
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	476,169,978.7	0.00	476,169,978.7

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөг/	
	2015 оны 12 дугаар сарын 31	2016 оны 12 дугаар сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	148,041,990.6	215,195,624.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,351,152.2	100,724,948.6
Нийтлэг татварын бус орлого	77,502,484.2	100,337,762.7
Тусламжийн орлого	6,848,668.0	387,185.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	63,690,838.3	114,470,675.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	239,074,299.1	75,832,070.9
УРСГАЛ ЗАРДАЛ	239,074,299.1	75,832,070.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	222,110,889.3	62,869,021.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,642,086.1	10,459,486.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,983,495.5	1,814,811.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	893,639.4	1,079,613.7
Хангамж, бараа материалын зардал	190,511,988.9	39,628,354.2
Нормативт зардал	12,961.0	19,501.9
Эд хогшил, урсгал засварын зардал	117,555.6	133,411.4
Томилолт, зочны зардал	282,252.2	132,713.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,461,162.6	6,131,499.7
Бараа үйлчилгээний бусад зардал	7,205,747.9	3,469,629.3
ТАТААС	3,895.0	1,115,873.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,959,514.8	11,847,175.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(91,032,308.5)	139,363,553.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	159,338.7	160,420.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	49,581,571.5	99,408,397.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49,581,571.5	99,408,397.3
Дотоод эх үүсвэрээр	49,581,571.5	99,408,397.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(49,422,232.8)	(99,247,976.7)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	165,780,048.1	1,903,356.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	13,071,253.9	3,215.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	23,628,537.1	40,567,092.4
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	129,080,257.0	(38,666,951.1)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(11,374,284.3)	1,448,625.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,894,859.6	14,520,575.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,520,575.3	15,969,201.1

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Тайлант 2016 оны		Зөрүү
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,894,112.5	65,837,815.1	(56,297.4)
УРСГАЛ ЗАРДАЛ	12,836,839.0	11,770,463.2	(1,066,375.8)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,941,505.2	4,974,521.8	(966,983.4)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,927,199.7	1,921,510.4	(5,689.3)
Үндсэн цалин	1,249,143.6	1,243,626.8	(5,516.8)
Нэмэгдэл	487,494.3	486,492.5	(1,001.8)
Унаа хоолны хөнгөлөлт	104,313.0	105,279.4	966.4
Гэрээт ажлын хөлс	86,248.8	86,111.7	(137.1)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	212,171.8	211,347.9	(823.9)
Тэтгэврийн даатгал	135,065.3	134,462.0	(603.3)
Тэтгэмжийн даатгал	15,436.2	15,392.1	(44.1)
ҮОМШӨ-ний даатгал	19,272.0	19,216.8	(55.2)
Ажилгүйдлийн даатгал	3,854.4	3,843.4	(10.9)
Эрүүл мэндийн даатгал	38,543.9	38,433.6	(110.3)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,004.0	48,520.5	516.5
Гэрэл, цахилгаан	156.0	90.2	(65.8)
Түлш, халаалт	837.0	751.8	(85.2)
Цэвэр, бохир ус	492.0	485.7	(6.3)
Байрны түрээс	46,519.0	47,192.8	673.8
Хангамж, бараа материалын зардал	119,667.1	118,676.1	(991.0)
Бичиг хэрэг	33,355.7	29,320.3	(4,035.4)
Тээвэр, шатахуун	30,289.5	29,396.3	(893.3)
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,341.9	27,437.2	7,095.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,623.4	1,238.2	(385.2)
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,056.6	31,284.2	(2,772.4)
Нормативт зардал	640.0	640.0	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	640.0	640.0	-
Эд хогшил, урсгал засварын зардал	29,484.1	27,328.8	(2,155.3)
Багаж, техник, хэрэгсэл	20,409.2	20,409.2	-
Урсгал засвар	9,074.9	6,919.6	(2,155.3)
Томилолт, зочны зардал	21,837.2	19,362.3	(2,474.9)
Дотоод албан томилолт	21,837.2	19,362.3	(2,474.9)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,230,841.0	2,379,511.4	(851,329.6)
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,973,382.4	2,123,029.4	(850,353.0)
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.0	1,000.0	-
Даатгалын үйлчилгээ	7,780.0	7,780.0	-

Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тээврийн хэрэгслийн татвар	1,720.0	1,142.5	(577.5)
Тээврийн хэрэгслийн оношлогоо	700.0	610.0	(90.0)
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,833.6	23,599.7	(233.9)
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	222,425.0	222,349.9	(75.1)
Бараа үйлчилгээний бусад зардал	351,660.3	247,624.5	(104,035.8)
Бараа үйлчилгээний бусад зардал	351,660.3	247,624.5	(104,035.8)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,895,333.8	6,795,941.5	(99,392.3)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	6,687,842.4	6,591,611.9	(96,230.5)
Засгийн газрын дотоод шилжүүлэг	6,686,148.2	6,589,917.7	(96,230.5)
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,694.2	1,694.2	-
Бусад урсгал шилжүүлэг	207,491.4	204,329.6	(3,161.8)
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	61,936.7	59,802.1	(2,134.6)
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	145,554.7	144,527.5	(1,027.2)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,420,746.6	54,067,351.8	1,646,605.3
Дотоод эх үүсвэрээр	52,420,746.6	54,067,351.8	1,646,605.2
Барилга байгууламж	49,435,546.6	51,515,825.7	2,080,279.1
Их засвар	2,559,500.0	2,125,836.2	(433,663.8)
Тоног төхөөрөмж	425,700.0	425,690.0	(10.0)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	636,526.9	-	(636,526.9)
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	636,526.9		(636,526.9)
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,894,112.5	64,501,392.8	(1,392,719.7)
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,042,910.0	59,387,728.4	(2,655,181.6)
Улсын төсвөөс санхүүжих	62,042,910.0	59,387,728.4	(2,655,181.6)
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,100,000.0	4,726,478.4	2,626,478.4
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,100,000.0	4,726,478.4	2,626,478.4
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,751,202.5	387,185.9	(1,364,016.5)
Хандив тусламж /гадаад/	1,751,202.5	387,185.9	1,364,016.5)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,894,859.6	10,123,891.9	(15,770,967.7)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,123,891.9	11,199,188.8	1,075,296.9
АЖИЛЛАГСАДЫН ТОО	131.0	131.00	-
Удирдах ажилтан	13.0	13.00	-
Гүйцэтгэх ажилтан	106.0	106.00	-
Үйлчлэх ажилтан	12.0	12.00	-